Күнзийн сургаал номлол хөгжсөн Азийн орнуудын хөгжлийн үндэс нь энгэл ардыг ч энэрэн хайрладаг өгөөмөр засаглалын капитализмд үндэслэсэн Күнзийн сургаалийн удирдах ухаан төрд итгэх ухамсарыг төрүүлж энэ нь төрийн бодлогыг идэвхтэй хүлээн авах Зүүн Азийн улс төрийн соёлыг гаргахад хувь нэмэр оруулсан..

Тухайлбал, Күнзийн сургаал номлолд "Ард түмэн бол төр улсын үндэс. Үндэс бат бэх байж улс орон амар тайван байна", "Энгэл ард бол хамгийн эрхэм, удаах нь түшмэл, харин хаан бол хамгийн сүүлд" гэх мэтээр айлдсан байдаг.

Күнзийн ардчилсан үзэл ард түмэнд төрийн талаарх итгэлцлийг төрүүлэх үндэс болж ирсэн.
=> Төрийн удирдлагат хэлбэрийн эдийн засгийг боловсруулах нь бодлогын амжилтын хүчин зүйл

22

- Күнзийн сургаалийн мөн чанар : тууштай, арвилан хэмнэх, үнэнч байдал бүхий зэрэг ухамсар, боловсрох гэгээрэхийг чухалчилдаг, олны хүчийг нэгтгэх, эвлэлдэн нэгдэх зэрэг аливаа улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжих соёлын баялаг хийгээд нийгмийн баялагын үүрэг гүйцэтгэж ирсэн.

Тухайлбал Дэлхийн 2-р дайнаас хойш Күнзийн сургаалаас хөрөнгөтний үзэлтэй уялдах ёс суртахууны үзэл нь 1960-аад оноос хойш улсын хөгжлийн бодлогыг дэмжих нийгмийн баялаг болж ирсэн.

=> Күнзийн соёлын шинжийг нийтлэг хүчин зүйл болгох эдийн засгийн интеграцичлалын онол

23

3. Ёс суртахуунт зах зээлийг байгуулах нь
(Күнзийн соёлын нийтлэг шинжийн ач холбогдол)

1) **Күнзийн номлолын эдийн засгийн үзэл : Ёс суртахуунт эдийн засгийн онол**
- Ашгийн төлөөх эдийн засгийн үйл ажиллагааг ч нийгмийн дэг журамд хал балгүйгээр зөв шударгаар явуулахыг чухалчилдаг.

- Сүнз: "Дутагдаж буй эд материалаар хязгааргүй шунаг хүслээ гүйцэлдүүлэхийг хичээх юм бол өөрөө зовох тул шунал хүслээ дарж яв"гэж чухалчилдаг.

24

2) Хүн байгалийн шүтэлцээний тухай үзэл :

-Байгалийг өөрийн эрхшээлд оруулах бус байгальтай шүтэлцээтэй амьдрахыг чухалчилдаг ⇒ Хүний тогтвортой оршин тогтнох үндэс болно.

- Хэтрүүлэн зарцуулах шунаг хүслээ дарж, дутуудах хэтрүүлэхийг хэм тэнцүүлж байх

: Үйлдвэрлэл ба хэрэглээг зохицуулахыг шаардана..

3)Хүнлэг ёс нийтлэг ёсны үзэл

- Хүн, ёс суртахуунаас гадуур арилжааны шинжтэй эд баялгийн хуримтлалаас татгалз

- Баян чинээлэг байхыг хязгаарлаж бүгд хамтдаа амьдрах нийтлэг ёсны эдийн засгийн ухагдахуун

「 Дутагдал гачигдлаас бус тэнцвэргүй, зохицолдоогүй зүйлээс шалтгааныг хай

- Минз: Ард түмэн амьжиргаа залгуулах эх үүсвэрийг тавьж өгсөн цагт л ёс суртахуунч сэтгэл хадгалагдан үлдэхийг баталсан. Ард иргэдийн жигд амьдралын нөхцлийг бүрдүүлэх

25

4) Хөрөнгөтний үзлийн зах зээлийн эзийн засгийн хүнлэг бус, ёс суртахуунт бус шинж ба байгаль орчин сүйдэх асуудлыг шийдвэрлэх арга

. - Дараах үеийн аж үйлдвэрийн нийгэм : уламжлалт нийгмийн хэв журмын уналт, хувийн шунал хүслээ үл дарах , хэт их өрсөлдөөний улмаас хүний ёсоо алдах асуудал гарч байна.

▪Күнзийн сэтгэлгээний ухаан

▪: Энэ мэт зах зээлийн эдийн засгийн асуудлыг арилгахад ёс суртахуун, хүний мөн чанарын төлөвшлийг үндэс болгох

▪Күнзийн ёс суртахуунч, эдийн засгийн үзэл

▪: Солонгос, Хятад, Япон нийтээр хүлээн зөвшөөрөх соёлын нийтлэг тал

▪.Зүүн хойд Азийн хамтын нийгэмлэгийг байгуулах зорилт

: **Күнзийн сургаалийн ёс суртахуун+Зах зээлийн үндэс=Ёс суртахуунт зах зээлийн эдийн засгийн бүс**

❖Зах зээлийн эдийн засгийн хүрээг ёс суртахуунжуулах

Тэнцвэртэй хөгжлийн тулд бүсийн хамтын ажиллагааны нийгэмлэгийг байгуулах шаардлагатай : Дэлхийн тавцанд ч Зүүн хойд Азийн хамтын нийгэмлэг бүрэлдэх нь ач холбогдолтой

26

Ⅴ. Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хэтийн төлөв ба эрхэм зорилт

1 Дэлхийн эдийн засгийн төв тэнхлэг болж буй Зүүн, Зүүн хойд Ази

- ▪ Зүүн Ази : хурдацтай хөгжил, эдийн засгийн хүч, зах зээлийн далайц, хүн ам зэрэг дэлхийн хөгжлийн төв тэнхлэг : Дэлхийн дэг журмыг гаргах боломжтой
- **Чөлөөт худалдааны хэлэлцээрийн олон талт байдал - Дэлхийн эдийн засгийн олон туйлт тогтолцоо**



Page 27

Ⅴ. . Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хэтийн төлөв ба эрхэм зорилт

1) 21-р зуунд дэлхийн интеграцичлалын гол тэнхлэг болох боломжтой : **Arnold Toynbee**

▪ Олон улсын дэг журмыг гаргах, бүсийн интеграцичлалын гүн ухаан болон эрхэм зорилт

▪ Зүүн Азийн эдийн засгийн үзлийн давуу талыг тусгах

–Жишээ) Күнзийн санааг орчин үед тусгах

: Ёс суртахуунт эдийн засгийн ухаан, хүн ба байгалийн шүтэлцээ, хамтын нийгэмлэгийн ухагдахуун, хүнлэг ёс

2) Хөрөнгөтний үзлийн зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үйлчлэл

▪ Хөрөнгөтний үзлийн зах зээлийн эдийн засгийн асуудалтай тал

–түүнийг нөхөх, засах үндэс болох

3) Ёс суртахуунт зах зээлийн эзийн засгийн дэг журмыг гаргахад манлайлах

Зүүн Азид Зүүн хойд азийн зах зээлийн эдийн засгийн дэг журмыг гаргах шинэ үүрэг

- Тэрхүү эрхэм зорилт ба хариуцлагын тулд гол эзэн болон Зүүн хойд азийн бүсийн хамтын нийгэмлэг байгуулах шаардлагатай.

28



Гишүүн орон нутгуудийн илтгэл

Шиманэ муж(Япон улс)

Гуанжү хот(БНСУ)

Баянхонгор аймаг(Монгол улс)

Тувагийн БНУ(ОХУ)

NEAR Working-level
Workshop 2014

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫГ СЭРГЭЭН ХӨГЖҮҮЛСЭН ТУХАЙ
ИЦМУ, ДАМАЦКРИ ХАЛУУН РАШААН
1000km
Япон улсын Шиманэ мужийн захиргааны соёл, олон улсын хэлтсийн дарга
Вакацки Шинжи

Японы уламжлалт буудал
(халуун рашаанд түшиглэсэн)

Япон маягын сууц(Датами)

Халуун рашаан

Дамацкри халуун рашааны дэргэд 16 буудал байрлаж гудамж үүсгэсэн байдаг. Энэ нь Японд нэртэй халуун рашааны гудамж юм

1990-ээд онд жилд 800.000 хүн хүлээж авдаг байсан бол сүүлийн үед баг, хамт олноор ирэх жуулчдын тоо цөөрч 500.000 хүн хүрэхтэй үгүйтэй байна.

Эцэст нь 16 буудлаас 4 нь дампуурахад хүрсэн/2007-2008/

Багаар ирэх жуулчдын тоо буурсаар байсан тул ганц нэгээр аялах жуулчдыг татах арга зам хайх шаардлагатай болж аялал жуулчлалын шинэ стратегийг гаргасан.

Хос хоёрыг уулзуулдаг
「Ицму Тайшя」

「Эмэгтэй」жуулчдын очих дуртай газар


Арьс гоо гоо сайханд гойд сайн Японы
хамгийн урт түүхтэй халуун рашаан
1300 оны өмнөх ном
Арьсыг чийгшүүлэх найрлага ихээр агуулагдсан(Sati
cine эмийн компани судалсан)
Халуун рашаан ус тэр чигээрээ дээд зэргийн гоо сай
хны бүтээгдэхүүнд хэрэглэгддэг！

Хайрын зурхай үздэг газар「Яэгаки」

Өвлийн цөөрөм

Хүслийг биелүүлдэг чулуу/ Power Spot
Дамацкри


Цаас руу зоос шийдэхэд 15 минутын дотор ёроолд буувал хурдан гэрлэдэг гэж үздэг
14

Сайн танигдаагүй Power Spot –ын тухай

Эмэгтэй жуулчдыг татахын тулд "Хайр дурлалын зурхай үзэх" болон "Power Spot "-ыг удаан хугацааны турш идэвхтэй сурталчилснаар эмэгтэй жуулчдын тоо аажмаар нэмэгдсэн. Гэвч 2009 оноос Ицму Тайшяд засвар хийх болсноор эмэгтэйчүүд урьд үеийг бодвол их ирэхээ больсон.

Гэхдээ 2013 онд Ицму Тайшяг засч дуусахад заяаны ханиа олох гэсэн чин хүсэлтэй эмэгтэй жуулчид олноор зорин ирэх болсон.

“Яэгаки” зурхай үздэг газар(2013 он)

“Дамацкри”
(2013 он)

“Яэгаки” зурхай үздэг газар
(2013 он)

Үүний зэрэгцээ Дамацкри халуун рашааныг зорих эмэгтэй жуулчдын тоо ч нэмэгдсэн. Ялангуяа залуу эмэгтэйчүүд ихээр ирэх болсон.





Иргэдийн оюун санааны онцлогыг тусгах бүтээлч Гуанжү хотын стратеги

БНСУ-ын Гуанжү хотын Олон улс,
хамтын ажиллагааны хэлтэс

1. Оршил

БНСУ-ын Гуанжү хотын уриа бол "Бүтээлч хот (Creative City)" билээ.

Гуанжү хотын "Бүтээлч байдал" гэдэг нь сэргээгдэх, дахин үсрэлт хийх хот, шинэ цаг үеийн орчныг манлайлах хот, иргэдийн оюун санаа ба үнэ цэнэд үндэслэсэн тогтвортой хөгжих хот болоход оршиж байгаа юм.

Аж үйлдвэрийн эрин үеийн үзэл санаа, тогтолцоонд баригдсан хотууд нь өнөөгийн цаг үеийн урсгалд таарахгүй хоцрогдохоос өөр аргагүй тул урьдын энэхүү хуучин аргыг бүрэн халж, бүтээлч сэтгэлгээг бодит байдалтай уялдуулж чадсан хот л тогтвортой хөгжлийг бий болгож чадна.

Бүтээлч хот-Гуанжү хотын онцлог

Нэгдүгээрт, түүхэнд нэрээ үлдээсэн Гуанжү хот ардчилсан үзэл ба хүнийг эрхийг эрхэмлэдэг хот юм.

Хоёрдугаарт, дэлхийн чанартай спортын уралдаан, тэмцээнийг хотын хөгжлийн бодлоготой хослуулах шинэ арга барилаар хотыг дахин бүтээн байгуулах юм.

Гуравдугаарт, уламжлалт физик/механик/ аргаар хот дахин төлөвлөх аргыг халж, соёлын материаллаг хот болох юм.

2. Хот дахин төлөвлөх төсөл

“Сэргээх” /дахин зохион байгуулах / гэгч үг дэлхийн даяар цаг үеийн шаардлагад нийцэн гарч буй хотын парадигм юм. Гуанжү хотын захиргааны зүгээс хотыг дахин зохион байгуулахын зэрэгцээ өөрийн өвөрмөц өнгө төрхийг алдагдуулахгүй хадгалах бодлого баримтлан хэрэгжүүлж байна.

Хотыг дахин зохион байгуулахтай холбоотой бодлогын хамгийн анхаарал татууштай зүйл бол хуучирсан орон сууцыг шинэ зориулалтаар ашиглахын тулд дахин барих төсөл юм.

① 2015 оны Зуны универсиадын тамирчдын тосгон:

Гуанжү хот дэлхийн спортын түүхэнд анх удаа хотын төвийн хуучирсан орон сууцнуудыг “2015 оны зуны универсиадын тэмцээний тамирчдын хотхон” болгох зорилгоор дахин барьж байгаа бөгөөд одоо барилгын ажил ид явагдаж байна.

Айл өрхийг нүүлгэх арга хэмжээг урьдчилан авсны дагуу нийт өрхийг 8 сарын хугацаанд нүүлгэн шилжүүлнэ.

Энэ нь дунджаар нүүлгэн шилжүүлэхэд 2 жил гаруй хугацаа шаардагддаг Солонгосын бусад газрыг бодвол харьцангуй богино хугацаа бөгөөд иргэдийнхээ ая тухыг боддог Гуанжү хотын бодлогыг тодоор харуулж байгаа хэрэг юм.

Мөн 2769 айл өрхийн 2682 нь буюу 97% нь орон сууцны захиалга өгөх гэрээ хийж, 2012 оны 9 сард баригдаж эхэлсэн Хуанжон Жүгун орон сууцны 35 байранд 3726 өрх орохоор болсон бөгөөд энэ барилга 2015 онд баригдаж дуусна.

Гуанжү хот нь 2015 онд болох “Гуанжү- Зуны универсиад” тэмцээнийг зохион байгуулах эрхийг авсан бөгөөд тэмцээний үеэр тамирчдын байрлах хотхоны барилгыг барих төсөл загварыг төлөвлөж гаргахтай холбогдуулан энэ талаарх өөр олон хотуудын туршлагыг судалж үзсэн. Ингэж судалж үзэхэд, олон улсын тэмцээн зохион байгуулсан ихэнх хотуудын хувьд хотын захын ногоон бүсэд нэвтрэх юмуу орон сууцны зориулалттай газрыг сонгох зэрэг хялбар шийдлээр хийж байсан боловч үүнээс шалтгаалан хотын иргэдийн хувьд нийтийг хамарсан асуудал, бэрхшээл үүсч байсан байна. Иймд Гуанжу хот үүнээс эсрэгээр буюу “Согү Хуажон дун” хорооллын хуучирч удсан Жүгун орон сууцыг дахин ашиглахаар шийдсэн юм.

Барилгыг дахин засч барих аргаар тамирчдын хотхоныг байгуулахаар шийдвэрлэх үед тэр газарт амьдарч байгаа иргэдийг нүүлгэн шилжүүлэх асуудал, дахин барих нь ашигтай эсэх, тэмцээнээс өмнө хугацаанд нь амжиж барьж дуусгах зэрэг олон эргэлзээтэй асуудал нь үнэндээ аз туршсан хэрэг байв.

170 орны 20000 гаруй тамирчин оролцох Гуанжү 2015-Зуны универсиадыг зохион байгуулахын төлөө бэлдэж буй Гуанжү хотыг илэрхийлэх байгальд ээлтэй, энх тайванч, технологи хослуулсан, соёл шингэсэн гэх 4 хүчин зүйлийг тодорхойлж дэлхийн тамирчдын түүхэнд урьд хожид байгаагүй хот дахин зохион байгуулах аргаар тамирчдын хотхоныг байгуулна.

② Аз жаргалтай бүтээлч тосгоныг бий болгох нь

Хуучин хотын төвийн эзэнгүй, хаягдсан сууцыг янзлан “Аз жаргалтай бүтээлч тосгоныг бий болгох” төслийн хүрээнд бүтээлч, байгальд ээлтэй ногоон хотыг бий болгоно. Жишээ татахад Мүдэнсан уулын бэлд орших Дунгү Сансү 2 орон сууцны хорооллыг Худүмэй маүль буюу Худүмэй тосгон хэмээн нэрлэн хот маягийн 5 давхар орон сууцыг барьж байна.

Энэ нь хуучин хотын төвийг тосгон болгон иргэдийн амьдралыг сайжруулах гэсэн нийтийн зорилготой.

Гуанжү хотын 5 дүүргийг хоцрогдсон, хоцрогдох магадлалтай, идэвхтэй гэсэн 3 ангилалд хуваан идэвхтэй бүтээн байгуулалт явагдаж буй бүсийг түр орхин, хоцрогдсон болон хоцрогдох магадлалтай бүсэд анхаарч хотыг тэнцвэртэй хөгжүүлэх төлөвлөхийг гол зарчим болгож байна.

3. Төгсгөлийн үг

Гуанжү хот соёл урлаг, бусдаас давамгайлах ухамсар зэрэг биет, биет бус соёлын өв, хүчин зүйлийг хотын соёлын имиджд илүү тусгахыг хичээж байна.

Хотынхоо бодлогын чиг хандлагыг тодорхойлохдоо, иргэдээ хамгийн түрүүнд боддог, хүний эрхийг эрхэмлэсэн, түүх, соёл урлагын баялагтай, иргэд нийтээр аз жаргалтай бүтээлч хотыг байгуулах зорилго тавиад байна.

< Гуанжү 2015-Зуны универсиад тэмцээн >

* Хугацаа : 2015 оны 7 сарын 3-ны өдрөөс 7 сарын 14-ний өдрийг хүртэл

* Хаана : Гуанжү хотын дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах стадион

* Оролцох хүрээ : 170 гаруй орны 20000 оролцогч

* Төрөл : Нийт 21 төрөл(Албан ёсны 13 / Сонголттой 8)

• Албан ёсны төрөл : спортын гимнастик, волейбол, уран сайхны гимнастик,

сагсан бөмбөг, усан поло, сэлэлт, жүдо, хөл бөмбөг, ширээний теннис, туялзуур сэлэм, хөнгөн атлетик

• Сонголттой төрөл : Гольф, бадминтон, буудлага, сэлүүрт завь, тэквандо, бейсбол, сур харвалт, гар бөмбөг

* Зохион байгуулагч : Олон улсын их дээд сургуулийн спортын холбоо (FISU)

* Зохион байгуулагч : БНСУ-ын их дээд сургуулийн спортын хороо(KUSB),

2015 Гуанжү-Зуны универсиад зохион байгуулах хороо(GUOC)

“ШИНЭ СУМЫН ТӨВ”
ТӨСӨЛ
БАЯНХОНГОР АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР
Canadian Technology
Canadian Design
Canadian Materials


Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын
Газар
Баянхонгор аймаг
Canadian Technology
Canadian Design
Canadian Materials
❖ Баянхонгор аймаг нь Монгол орны баруун төв хэсэгт байрлаж баруун өмнөд талаараа Говь-Алтай, баруун талаараа Завхан, хойд талаараа Архангай, зүүн талаараа Өвөрхангай, зүүн өмнөд хэсгээрээ Өмнөговь аймагтай хиллэхээс гадна өмнө талаараа 140 км нутгаар БНХАУ-тай тус тус хиллэдэг.
❖ Баянхонгор аймгийн нийгэм эдийн засгийн байдал
❖ Нутаг дэвсгэр: 116,000 км2, 19 сумтай
❖ Хүн ам: 82,088 хүн (2006 оны байдлаар)
❖ Хүн амын нягтшил: 0.71
❖ Аймгийн төв: Баянхонгор хот нь нийслэл Улаанбаатар хотоос 639 км зайтай, хатуу хучилттай авто замаар холбогдсон. Мөн харилцаа холбоо сайтай. Бүх сумд үүрэн холбоотой, өндөр хүчдэлд холбогдсон.
❖ Ашигт малтмалын арвин их нөөцтэй.

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын
Газар
Баянхонгор аймаг,
Монгол улс
Canadian Technology
Canadian Design
Canadian Materials
WELCOME TO
BAYANKHONGOR
Хөдөөд Шинэ суурин төв
хөгжиж байна
Илтгэгч : Д. Эрдэнэбилэг
Аймгийн ЗДТГ-ын Төрийн Захиргаа Удирдлагын Хэлтэс, Гадаад харилцааны асуудал
хариуцсан мэргэжилтэн
2014.05.20


Баянхонгор Аймаг
Засаг Даргын
Тамгын Газар
Баянхонгор хот: Утаа
Canadian Technology
Canadian Design
Canadian Materials
❖ Баянхонгор хотод 30,000 орчим хүн ам оршин сууж байна.
❖ Үүнээс 71 хувь нь буюу 21,000 орчим хүн ам гэр хороололд амьдарч байна.
❖ 2013 îíû áàéäëààð Баянхонгоð õîò íь 8,4 мянган °рхтэйгээс íèéò °ðõèéí 71.5 õóâü буюу 6046 айл өрх ãýð õîðîîëîëä àìüäàð÷ ááéãàà нь:
➢ Агаарын бохирдол
➢ Хөрсний бохирдол
➢ Ая тухтай орчингүй
➢ Эрүүл мэнд, эрүүл ахуйн сөрөг нөлөөлөл зэрэг олон сөрөг хүчин зүйлүүдийн ãîë øàëòãààí áîëæ ááéíà.

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Баянхонгор хот: Утаа

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

❖ 2013 îíû áàéäëààð Баянхонгоð õîòод нийт дулаан үйлдвэрлэлийн **9** уурын зуух нүүрсээр галлаж дулаанаар хангаж байгаа нь :

- Агаарын бохирдол
- Хөрсний бохирдол
- Ая тухтай орчингүй
- Эрүүл мэнд, эрүүл ахуйн сөрөг нөлөөлөл зэрэг олон сөрөг хүчин зүйлүүдийн ãîë øàëòãààí áîëæ áàéíà.



Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Шилжилт хөдөлгөөн Баянхонгор хот

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

Migration: Region, by region
- North or Forest and Mountainous region
- Steppe Meadows region
- Gobi and Desert region

❖2011-2012 онд Баянхонгор хотоос Улаанбаатар хот болон бусад аймаг руу шилжин явсан хүний тоо 3917 байхад шилжин ирсэн хүний тоо 3253 байна.

❖2013 онд 1745 хүн шилжин ирж суурьшсан байна.

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Шилжилт хөдөлгөөн Улаанбаатар хот

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

Migration /region, by region/



2010
2000
1990

❖2000-2008 онд Нийслэл хотоос шилжин явсан хүний тоо 30,968 байхад шилжин ирсэн хүний тоо 287,130 байсан.

❖2009 онд 15,100 хүн шилжин ирж суурьшсан нь 5 сумын дундаж хүн амтай тэнцэж байна.

❖2010 онд нийт 16,000 өрх Улаанбаатар хотод шилжин ирж суурьшсан байна.

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Өнөөгийн сумын төв

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

❖ Баянхонгор аймгийн 20 сумын төв дэх барилга байгууламжийн дийлэнх нь хэт хуучирч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон

❖ Олон сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэг зориулалтын бус, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байранд байрладаг

❖ Тэдгээрийн их засварт жил тутам улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулдаг боловч үр дүн муутай байдаг

❖ Тарүү байрлалтай, дулаан хадгалалт муутай барилгуудад нам даралтын уурын зуухаар дулаан хангадаг учраас ашиглалтын зардал маш өндөр гардаг зэрэг олон хүндрэлтэй асуудлууд байна

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Еренхий төлөвлөлт

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials



Баянхонгор Аймаг
Засаг Даргын
Тамгын Газар

Шинэ бүтээн байгуулалт

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ❖2013-2014 онуудад Монгол улсын хэмжээнд 329 сумаас 3 суманд “Шинэ Сумын төв” төсөл буюу Шинэ сумын төв хөдөлгөөнийг өрнүүлж хамгийн анхны гарааг Монгол улсын Баянхонгор аймгаас эхлүүлж тус аймгийн Баянлиг, Бууцагаан сумын төвүүдийг шинээр цогцлоон бүтээн байгуулалт хийгдлээ.
- ❖Үр дүнд иргэд орон нутагтаа тав тухтай, тохилог сайхан орчинд амьдарч, ажиллах аюулгүй орчин бүрдлээ. Хөдөө нутагт хүний амьдралын бүхий л нөхцлийг хангасан, орчин үеийн, ногоон байгууламж бүхий дэд бүтэц, цахилгаан, дулаан, гэрэлтүүлгийг байгуулж, усан хангамжийн асуудал бүрэн шийдвэрлэгдсэн байна. Мөн хүүхэд, залуучууд чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх талбайтай, явган хүний зам, хүүхдийн тоглоомын иж бүрдэл бүхий цэвэрхэн суурииг барьж байгуулж болдгийг бид харж байна



Баянхонгор Аймаг
Засаг Даргын
Тамгын Газар

ШИНЭ СУМЫН ТӨВ

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- “Шинэ сум” төслөөр 640 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, 150 хүүхдийн дотуур байр, 20 ортой эмнэлэг, Сумын захиргаа, 180 суудалтай орчин үеийн Спорт ордон, 400-500 хүний багтаамжтай Соёлын төв, Цахилгааны дэд станц, усан сан, цэвэрлэх байгууламж, хөлбөмбөгийн талбай, автомашины зогсоол, гэрэлтүүлэг, явган хүний зам зэрэг хүний ая, тухтай амьдрах орчин хэрэгтэй бүгдийг барьжээ. Эдгээр барилга байгууламжуудыг барихын тулд Баянлигт 14,7, Бууцагаанд 14,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

“Шинэ сумын төв”

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ❖ “Шинэ Сумын төв” төсөл хэрэгжсэнээр дэлхийн дэвшилтэт Канад модон барилгын технологийг ашиглан, нэгдсэн цогц төлөвлөлтийн дагуу Төрийн үйлчилгээний цогцолборыг сумдын төвд байгуулж нэг цэгт төвлөрүүлсэн
- ❖ 10 жилийн баталгаатай, 90-120 жилийн эдэлгээтэй шинэ барилгууд баригдаж улсын төсвөөс их засварт зарцуулдаг хөрөнгийг мөн хугацаанд хэмнэсэн
- ❖ Эрчим хүчний хэмнэлттэй материал болон газрын гүний дулаан зэрэг шилдэг технологи ашиглаж дулаан, цахилгааны зардлыг 60% бууруулсан
- ❖ Тав тухтай, аюулгүй, цэвэр, “ногоон” барилга байгууламжид ажиллаж, сурч амьдрах нь байгаль орчин, эрүүл мэндэд нэн чухал ач холбогдолтой болж байгаа юм.



Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Канад модон барилгын технологийг яагаад нэвтрүүлсэн бэ

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- НҮБ-аас Канадыг хамгийн аюулгүй ба тав тухтай орон сууц бүхий улс хэмээн хүлээн зөвшөөрсөн
- Канадын барилгын стандарт нь дэлхийн хэмжээнд өндөр шаардлага хангасанд тооцогддог
- Хойд Америкийн нийт орон сууцны 90% гаруй хувийг модон барилгын технологиор барьдаг
- Канад улс газар зүй, цаг агаар, уур амьсгалын хувьд Монголтой төстэй бөгөөд эрс тэс цаг агаарын нөхцөлд тохирсон барилгын технологийг боловсруулсан
- Өртөг багатай, эрчим хүчний хэмнэлттэй, бат бөх, дулаан, барихад хурдан, эдэлгээ урт, эрүүл "ногоон" барилга юм

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Модон барилга Монголд

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- Стандарт: Монгол улс 2007 онд Канадын модон барилгын стандартыг нэвтрүүлж БНбД-31-09-07 тоотоор баталсан
- Технологи: Монголын 20 гаруй компани энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж, барилгын модон хийц үйлдвэрлэх 4 үйлдвэр ашиглалтанд ороод байна
- Хүчин чадал: Жилд 15.000 м2 барилга буюу 4.000 айлын орон сууцны модон хийц үйлдвэрлэн угсрах хүчин чадалтай
- Модон материал: Монголын ойн нөөц хомс, мод боловсруулалт технологийн шаардлага хангадаггүй, үнэ өндөр зэргээс шалтгаалан бүх модон материалыг Канадаас шууд импортлоно
- Боловсон хүчин: Канадын Британи Коломбын Их Сургуулийн тусламжтайгаар сургалтын програм, сурах бичиг, гарын авлагын монгол хэл дээр орчуулж, Канадын сургагч багш нараар ШУТИС –ийн багш нарыг бэлтгэж, улмаар тус сургалтанд 400 гаруй мэргэжлийн ажилчин бэлтгээд байна.

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Модон барилгын давуу тал

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

Канадын модон барилгыг энгийн цементэн барилгатай харьцуулахад:

- Барилгын өртгийг 30-40% хэмнэнэ
- Ашиглалтын зардлыг 50-70% бууруулна
- Барилга угсралтын ажлыг 3-4 дахин богино хугацаанд гүйцэтгэнэ
- Жилийн 4 улиралд барих боломжтой
- 64 см зузаан дан цементэн хананаас 6.2 дахин дулаан хадгална
- Бат бөх чанар нь АНУ-ын Флорида-гийн хар салхи, Японы Кобе-гийн газар хөдлөлт зэрэгт нотлогдсон
- Модон барилгад байнга оршин суудаг хүний дундаж наслалтыг 8 жилээр нэмдэг нь судалгаагаар тогтоогдсон

Баянхонгор Аймаг Засаг Даргын Тамгын Газар

Канадын техникийн туслалцаа

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ЗТБХБ яам нь Канад улсын Эрдэс баялгийн яам, Британийн Колумб мужийн Ой модны яам болон Ой модны хөгжил, хөрөнгө оруулалтын агентлаг зэрэгтэй Канадын модон барилгын технологийг Монголд нэвтрүүлэх талаар идэвхтэй хамтран ажиллаж ирсэн
- Цогцолборын дизайн, зураг төслийг Канад улсын Ой модны яамны техникийн туслалцааны хүрээнд гүйцэтгэнэ
- Цогцолборын барилга угсралтын ажлыг Британийн Колумбын Ой модны хөгжил, хөрөнгө оруулалтын агентлагийн инженер, техникийн ажилчид удирдан явуулна

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Орчин үеийн дэд бүтэц

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ❖ Цогцолборын дэд бүтцийг мөн Канад болон бусад улсын тэргүүлэх технологи ашиглан хангана
- ❖ Цахилгаан: төвийн цахилгаан хангамжгүй сумдад нар, салхи болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглана
- ❖ Дулаан: цогцолборын дулаан болон халуун усыг газрын гүний дулааныг хураан хуримтлуулдаг Канадын GeoSmart технологийг ашиглан хангана. GeoSmart нь ашиглалтын зардлын хувьд цахилгаан бойлераас 3,1 дахин, уурын зуухнаас 2,3 дахин хэмнэлттэй, аливаа төрлийн түлш шатаадаггүй, цэвэр "ногоон" бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй систем юм
- ❖ Бохир: Канадын био-септик систем



Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Цогцолборын байгууламж

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ❖ Цогцолборын ерөнхий төлөвлөлтийг олон улсын жишиг болон Монгол улсын хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрмийг (БНбД 30-01-04) үндэслэн гаргав
- ❖ Цогцолборт сумын захиргаа, сургууль, дотуур байр, цэцэрлэг, соёл спортын төв, эмнэлэг зэрэг 6 барилга багтана
- ❖ Сумын дундаж хүн амыг 5,000 хүнд тооцов
- ❖ Цогцолборын нийт талбай: 5,6 га
- ❖ Цогцолборын барилгын талбай:13,220 м2
- ❖ Ногоон байгууламжийн талбай: 2,2 га
- ❖ Цогцолборын дизайн, зураг төслийг Канад улсын Ой модны яамны техникийн туслалцааны хүрээнд хийж гүйцэтгэх бөгөөд УИХ-ын гишүүн Х.Баттулгын санаачилгаар уг төслийг Баянхонгор аймгийн 18 суманд хэрэгжүүлнэ. Одоогоор 2 сумын төв ашиглалтанд орж байна.

Төв Хаалга

Сумын захиргаа

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Хонины ноосон дулаалгын материал

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

- ❖ Канад, Их Британи, Австрали, Герман зэрэг улсад өргөнөөр ашиглаж эхлээд байгаа дулаалгын шинэ технологи
- ❖ ХНДМ-ыг бусад төрлийн дулаалгын материалтай харьцуулахад:
- ❖ Дулаан хадгалалт (0.039 W/mK) болон дуу тусгаарлалт илүү
- ❖ Гал, чийг, мэрэгчид тэсвэртэй
- ❖ Эдийн засгийн хэмнэлттэй
- ❖ Экологийн "ногоон" бүтээгдэхүүн
- ❖ Дэлхийн тэргүүлэх технологи бүхий үндэсний шинэ үйлдвэр байгуулж ажлын байр нэмэгдүүлнэ
- ❖ Дотоодын түүхий эд ашиглан экспортын шинэ бүтээгдэхүүн гаргана
- ❖ Хонины ноосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж үнийг тогтворжуулна, улмаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Хот төлөвлөлт

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

Баянхонгор хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө:
Баянхонгор аймгийн Баянхонгор хотыг 2013-2033 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Солонгос улсын "SOOSUNG ENGINEERING" компанийн Хот төлөвлөлтийн хэлтэстэй хамтран гүйцэтгэж байна.

Энэ компани бол Солонгос улсдаа төдийгүй олон улсад нэр хүндтэй компани бөгөөд 2013 оны 8 сараас эхлэн судалгааны ажил, хот төлөвлөлтийн мастер төлөвлөгөөг гүйцэтгэж байна.

Баянхонгор Аймаг
Засаг Даргын Тамгын Газар

Төслөөс гарах үр дүн

Canadian Technology
Canadian Design
Canadian Materials

Баянхонгор аймгийн сумдын хувьд:

1. Дэлхийн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж орон нутагт баригдсанаар хөдөө орон нутгийн иргэд Төрийн чанартай нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжоор хангагдана.
2. Төрийн захиргааны ажлын байрны таатай нөхцөл бүрдсэнээр Төрийн үйлчилгээний имидж сайжирч төрийн үйлчилгээний ил тод байдал, хариуцлага нэмэгдэнэ.
3. Төвийн болон орон нутгийн дэд бүтцийн уялдаа холбоо сайжирч, иргэд үйлдвэрлэл үйлчилгээ, ажил эрхлэх сонирхол нэмэгдэж амьдралын хүрэлцэхүйц орлого олох боломжтой болно.
4. Эрчим хүч, дулаан ашиглалтын хэмнэлттэй орон сууц, барилга байгууламж баригдсанаар нүүрсний хэрэглээгүй болж агаарын бохирдол буурна.
5. Орон нутгаас хотруу чиглэсэн хүн амын төвлөрөл, шилжилт хөдөлгөөн багасч түүнээс үүдэн гардаг ажилгүйдэл, ядуурал, шилжигсэдийн бичиг баримтын зөрчилтэйн улмаас нийгмийн суурь үйлчилгээ авч чадахгүй байх, орон гэргүй иргэдийн тоо өсөх, улмаар гэмт хэрэг нэмэгдэх гэх мэт сөрөг үр дагаврууд эрс буурна.
6. Сумын төвийн дэд бүтцийн барилга байгууламжийн их засварт жил бүр үр дүн багатай зарцуулагддаг 10-12 тэрбум төгрөгийн зардлыг эрс бууруулна.
7. Хот байгуулалт, төлөвлөлт, газрын харилцаа Олон улсын түвшинд хөгжинө.



ОХУ-ын Тувагийн БНУ, БНСУ хоорондын хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Тувагийн БНУ-ын
Компанийг дэмжих сан

2006 оны 12 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд Зүүн Хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан "Зүүн хойд Азийн бүсэд бизнесийг дэмжих бага хурал"-д ОХУ-ын Тувагийн БНУлсын төлөөлөгчид оролцсон.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны шалгаруулалтанд Тувагийн БНУ-ын Гадаад эдийн засаг, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн М.П.Монгуш тэнцэж, 2007 оны 5 дугаар сараас 2008 оны 5 дугаар сарын хооронд Холбооны Хэрэг эрхлэх газарт 1 жилийн хугацаатай ажиллав.

Тувагийн БНУ-ын Засгийн газрын тэргүүний 1 дүгээр орлогч Ш.С.Иргит болон Тува улсын Иргэний хамгаалалт, онцгой байдлын газрын дарга Н.М.Монгуш нараар ахлуулсан төлөөлөгчид 2011 оны 3 дугаар сарын 5-14-ны өдрүүдэд Япон улсын Хёго мужийн Кобэ хотноо болсон "Гамшгаас хамгаалах хороо"-ны хуралд оролцсон.

2011 онд Тува улсын дуу бүжгийн "Саяны" чуулгын уран бүтээлчид БНСУ-ын Чонан хотноо болсон "Дэлхийн ард түмний бүжиг" сэдэвт олон улсын уралдаанд оролцож, нийт 21 орны 23 оролцогчдаас 3 дугаар байрт шалгаран хүрэл медаль хүртсэн.

2013 оны 2 дугаар сард ОХУ-ын Красноярск хотноо болсон "Эдийн засгийн форум"-ын хүрээнд, БНТува улсын Засгийн газрын тэргүүн Ш.В Кара-Оол нь ОХУ-ын Эрхүү муж дахь БНСУ-ын Ерөнхий консул Чон Дон Ён болон Консулын газрын ажилтнуудтай 2 дугаар сарын 15-ны өдөр уулзаж, энэхүү уулзалтын хүрээнд "Тэс-Хэмскийн нутаг дахь Элегестскийн нүүрсний ордыг олборлохтой холбогдуулан Кызыл-Курагино чиглэлийн төмөр зам барих төсөл"-ийн талаар Ерөнхий консулд танилцуулсан байна.

2013 оны 5 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд Солонгос улсын Кёнсанбуг мужийн Пухан хотноо болсон ЗХАБНЗЗХ-ны гишүүн орон нутгийн Гадаад харилцааны ажилтнуудын хуралд БНТува улсын Гадаад эдийн засгийн газрын дарга Ч.Ч-Д.Ондар оролцов. Энэ үеэрээ Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Же Хю, Хэрэг эрхлэх газрын дарга Ким Донг Соль нартай уулзаж, Тува улсын Шагонар хотод Цементийн үйлдвэр, Кызыл хотод шилний үйлдвэрийн барилга барихад хөрөнгө оруулж дэмжлэг үзүүлэх тухай, Тувагийн "Улсын Лицей сургууль"-д солонгос хэлний багш авч ажиллуулах тухай, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, аялал жуулчлалын хамтарсан компани байгуулах, хүүхэд багачуудыг зуны амралтыг өнгөрүүлэх хамтарсан арга хэмжээ зохион байгуулах гэх мэт асуудлуудыг хэлэлцэж ярилцсан байна.

2013 оны 8 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд ЗХАБНЗЗХ-ны Хэрэг эрхлэх газрын төлөөлөгчид БНСУ болон Тувагийн БНУ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг хэлэлцэх зорилгоор Тува улсын Кызыл хотод айлчлав. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ЗХАБНЗЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Ким Дже Хю, орос хэлний мэргэжилтэн Чой Кен Нам, Холбооны Хэрэг эрхлэх газрын Төлөвлөлт, ерөнхий удирдлагын хэлтсийн дарга Хонг Джун Ву нар оролцсон бөгөөд айлчлалын хүрээнд Тува улсын Засгийн газрын гишүүдтэй уулзаж, хөрөнгө оруулалтын төслүүд (Тува улсад цаа бугын аж ахуйг хөгжүүлэх тухай) болон оюутан сурагчдыг харилцан солилцох, жуулчид солилцох, хөрөнгө оруулагчдыг татах гэх мэт ойрын ирээдүйд хамтран ажиллах боломжуудын талаар хэлэлцсэн байна.

2013 оны 11 дүгээр сард БНСУ-д айлчилсан ОХУ-ын Засгийн газрын албаны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Тува улсын ЗГ-ын тэргүүн Ш.В.Кара-оол орж ажиллан, энэхүү айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан Орос-Солонгосын бизнесийн 6 дугаар уулзалт болон ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин, БНСУ-ын ерөнхийлөгч Пак Гын Хе нарын 2 талын болон бүс нутгийн хөтөлбөрийн асуудлаар өргөн хүрээнд ярилцсан уулзалт ярилцлагад тус тус оролцсон. Дээрх бизнес ярилцлагын үеэр мэдээллийн технологи, инноваци, эрчим хүч, байгалийн баялаг, тээвэр, дэд бүтэц, худалдаа болон жижиг дунд бизнесийг дэмжих, орон нутаг, мужийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлууд хэлэлцэгдсэн байна.

2014 оны 2 дугаар сарын 11-нд ЗХАБНЗЗХ-ноос 2013 онд зохион байгуулсан "Миний мэдэх Зүүн Хойд Ази" сэдэвт зохион бичлэгийн уралдаанд амжилттай оролцсон оролцогчдыг Тува улсын Засгийн газрын тэргүүн Ш.В.Кара-Оол хүлээн авч уулзав. Тува улсын сургуулийн сурагч, оюутан зэрэг нийт 7 залуу иргэн энэхүү уралдаанд оролцож, олон улсын хэмжээнд өөрсдийн бүтээлээ үнэлүүлсэн байна.

2014 оны 4 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд БНСУ-ын Солонгосын Тээврийн Их сургуулийн төлөөлөгчид Тува улсын нийслэл Кызыл хотод айлчилсан. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тус сургуулийн олон улсын хамтын ажиллагаа хариуцсан проректор, хэл бичгийн шинжлэх ухааны доктор, солонгос хэл уран зохиолын тэнхимийн профессор О Ён Ми, Олон улсын харилцааны хэлтсийн зөвлөх, улс төрийн шинжлэх ухааны профессор Пак Жон Кван болон Олон улсын харилцааны хэлтсийн ажилтан Пак Жон Сул нар оролцсон бөгөөд тэдний айлчлалын зорилго гол зорилго нь Тувагийн их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломжийг судлах, мужийн удирдлагуудтай ажил хэргийн холбоо тогтоох асуудал байсан.

Солонгосын төлөөлөгчид Тува улсын Ерөнхий сайдын орлогч Анатолий Дамба-Хууралтай уулзаж, багш, оюутан солилцох тухай болон цаашдын хамтын ажиллагааны бусад арга хэлбэрүүдийн талаар санал солилцож ярилцсан бөгөөд энэ үеэрээ Солонгосийн Тээврийн их сургууль нь ОХУ-ын олон их, дээд сургуулиудтай харилцаа холбоотой ажиллаж, хамтарсан төслүүдийг хэрэгжүүлдэг болохыг тэмдэглэн хэлж байсан.

Айлчлалын хүрээнд төлөөлөгчид Тувагийн их сургууль, Кызылийн тээврийн техникумын оюутнуудтай уулзаж, Солонгосын Тээврийн их сургуулийн тухай танилцуулга хийсэн. Уулзалтанд оюутнуудаас гадна Тувагийн их сургуулийн ректор О.М.Хомушка, Кызылийн Тээврийн техникумын захирал Ю.Н.Сенников, Тува улсын Боловсролын яам, Залуучууд, спортын яамны төлөөлөл болон Тува улс дахь зарим солонгос иргэд оролцсон байна.

Түүнчлэн эдгээр төлөөлөгчид Тувагийн "Улсын лицей сургууль"-ийн захирал Т.О.Санчаатай уулзаж, талууд цаашид хамтран ажиллах, Улсын Лицей сургуулийн төгсөгчдийг Солонгосын Тээврийн их сургуульд элсүүлж авах, Лицей сургуулийн сурагчдыг 2014 оны зун их сургуульдаа зочлуулах зэрэг асуудлыг уулзалтын үеэр ярилцаж тохиролцсон.

Энэхүү айлчлалын үр дүнд БНСУ-ын Тээврийн их сургууль, Тувагийн Их сургуулийн хооронд хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан ба хамтран ажиллах гол чиглэл нь эрдмийн солилцоог хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтарсан төсөлд оролцох асуудал юм. Түүнээс гадна БНСУ-ын Тээврийн их сургууль, Тува улсын Улсын Лицей сургуулийн хооронд хамтран ажиллах протокол үйлдсэн байна.

Гишүүн орон нутгуудийн арга хэмжээний зар, санал

○ Харбин-Олон улсын эдийн засаг, худалдааны 25-р уулзалт болон Хятад-Оросын эдийн засгийн анхдугаар үзэсгэлэн

○ Гамшгаас сэргийлэх хорооны зар

○ Боловсрол, соёлын хорооны зар

○ 2014 GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн Амьд биетийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

○ Био эмчилгээний аж үйлдвэрийн хорооны зар

○ Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын хорооны зар

○ Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын Холбоотой хамтран ажиллах санал

NEAR Working-level Workshop 2014

25 дахь удаагийн Харбин-Олон улсын эдийн засаг, худалдааны уулзалт болон Хятад-Оросын анхдугаар үзэсгэлэн болох тухай

Хэйлонжан мужийн гадаад
харилцааны хэлтэс

Эрхэм хүндэт Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жэ Хю

Зочид төлөөлөгчид өө

Сайн байцгаана уу

Юуны өмнө энэхүү хурлыг амжилттай зохион байгуулахын тулд хичээл зүтгэл гаргасан Холбооны Хэрэг эрхлэх газрын ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жэ Хю болон түүний хамт олонд талархал илэрхийлье.

Энэ завшааныг ашиглан та бүхэнд Хэйлонжан мужаас зохион байгуулах "Харбин-Олон улсын эдийн засаг, худалдааны уулзалт болон Хятад-Оросын анхдугаар үзэсгэлэн"-гийн тухай танилцуулья.

Ирэх 6 сарын 30-ны өдрөөс 7 сарын 4-ний өдрийг хүртэл Хятад улсын Худалдааны яам, Хэйлонжан мужийн ардын засаг, ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яам, мөн Аж үйлдвэр худалдааны яамнаас хамтран 25 дахь удаагийн Харбин-Олон улсын эдийн засаг, худалдааны уулзалт болон Хятад-Оросын анхдугаар үзэсгэлэнг Харбин хотноо зохион байгуулна.

Нийт 86000㎡ талбайд олон улсын стандартын 3000 бүхээгт тэргүүний технологи, орчин үеийн газар тариалан, барилгын материал болон хөнгөн аж үйлдвэр, электрон төхөөрөмж, гадаадын орнуудын, тавилгын хэсэг ангилалаар үзэсгэлэн гарахаас гадна бизнесийн төрөл бүрийн арга хэмжээ болно.

Хамтын ажиллагааг өргөжүүлж, ойлголтыг нэмэгдүүлэх 25 дахь удаагийн Харбин-Олон улсын эдийн засаг, худалдааны уулзалтад та бүхэн оролцсоноор худалдаа, хөрөнгө оруулалтын өргөн боломж нээгдэх ба шинжлэх ухаан, технологийн харилцаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа бий болгох юм. NEAR Холбооны гишүүн орон нутгийн захиргаад, орон нутгийн компаниудын хамтаар уг үзэсгэлэн, хуралд идэвхитэй оролцохыг хүсье. Бид Холбооны гишүүн орон нутгийн компаниудад бүхээг түрээслэх, бизнесийн үйл ажиллагаа сурталчлах, бизнесийн түнш зуучлах зэрэг төрөл бүрийн тусламж үйлчилгээг харамгүй үзүүлэх болно. Уг арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www. China-russiaexpo.org сайтаас авч болно.

Хэйлонжан муж ба NEAR Холбооны гишүүн орон нутаг хооронд найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг нэг шат ахиулж өргөжүүлэхийн тулд тус мужийн Ардын засаг болон өөрийн ажиллаж буй гадаад харилцааны хэлтсийн нэрийн өмнөөс Холбооны гишүүн орон нутгийн төлөөлөгчдийг тус арга хэмжээнд урьж байна. 6 сарын 30-ны өдрөөс 7 сарын 4-ний өдрийг хүртэлх арга хэмжээнд оролцох гишүүн орон нутаг бүрээс 3 хүртэлх хүний 5 өдрийн байр хоол, хот доторх тээврийн зардлыг бид хариуцах болно.

6 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл арга хэмжээнд оролцох хүмүүсийн нэрс, албан тушаал, паспортын дугаар, нислэгийн цагийн хуваарийг бидэнд мэдэгдвэл бид бэлтгэлийг хангах болно.

Хариусан ажилтан : Sui Zhi Bo

Факс : : 86-451-53607183

Утас : 86-451-53638051

Мэйл хаяг : suizhibo@aliyun.com

Төгсгөлд нь энэхүү хурлын ажиллагаанд амжилт хүсээд Холбооны гишүүн орон нутгийн захиргаа, компаний төлөөлөгчдийг Хэйлонжан мужид айлчлан ирж Харбины олон улсын эдийн засаг, худалдааны уулзалтад оролцохыг урьж байна.

Баярлалаа.

HYOGO PREFECTURE

Гамшгаас сэргийлэх хороо

【Гамшгаас сэргийлэх хорооны 12-р хурлын тайлан, дараагийн хурлын тухай】

2014. 5. 22

Хёго мужийн Олон улсын харилцааны хэлтсийн дарга Морияс Хидэказ

Hyogo Prefectural Government

1. Японы Ханшин-Аважид болсон хүчтэй газар хөдлөлтийн тухай

HYOGO PREFECTURE

Кобэгийн чиглэлийн Ханшиний хурдны зам

Газар хөдлөлтийн далайц

Хэзээ: 1995.1.17-ны өдөр 5 цаг 46 минут

Хамрах газар: Ивуажи арлын хойд хэсэгт16 км гүнд

Балл: M7.3 Анхны чичирхийлэлт 7 балл

Хохирлын хэмжээ

Хохирол:
Нас барсан 6,402 хүн
Хохирлын мөнгөн дүн 10 триллион иен
Газар хөдлөлтөд өртсөн 104,004 сууц (182,751 өрх)
Дүрвэгсдийн тоо 316,678 (1995.1.23)

Газар хөдөлсний дараа (Кобэ хотын Нигата дүүрэг)

2. Гамшгаас сэргийлэх хорооны 12-р хурал

HYOGO PREFECTURE

JICA-гийн Кансай дахь салбарын арга хэмжээ

Оролцогчид:

4 орны 16 орон нутгийн 30 төлөөлөгч оролцсон.
Үүнд: Нинся Хуйн ӨЗО, Шаньдун муж, Чүнчонбүг муж, Сэжун хот, Кёнсаннам муж, Жолланам муж,Пусан хот, Ульсан хот, Өвөрхангай аймаг, Говь-Алтай аймаг, Сэлэнгэ аймаг, Дорноговь аймаг, Сахалин муж, Сахагийн БНУ, NEAR Холбооны Хэрэг эрхлэх газар

Гол хөтөлбөр

3 сарын 11-нд:
① Хүн ба гамшгаас сэргийлэх ирээдүйн төв
② Илтгэл "Японы Зүүн нутгийн хүчтэй газар хөдлөлтийн дараах Хёго мужийн тусламж үйлчилгээ"
③ Олон улсын гамшгаас сэргийлэх байгууллагуудын төлөөлөлт санал бодол солилцох
④ JICA Кансайн салбарын арга хэмжээ "Гамшгаас сэргийлэх салбарын боловсон хүчнийг хөгжүүлэх үйл ажиллагаа"
⑤ Хүлээн авалт
3 сарын 12-нд:
Гамшгаас сэргийлэх төв, Кобэ хотын Аюулыг хянах төв зэрэг газартай танилцах

Гамшгаас сэргийлэх төв

3. Дараагийн арга хэмжээний төлөвлөгөө

HYOGO PREFECTURE

- ○ Ханшин Аважигийн хүчтэй газар хөдлөлт болсон 1 сарын 17-ны өдрийг Хёго мужийн аюулгүйн өдөр хэмээн зарлан жил бүрийн эл өдөр тэмдэглэлт арга хэмжээ зохиох болсон.
- ○ 2015 оны 1 сарын 17-ны өөр Ханшин Аважид газар хөдөлсний 20 жилийн ой тохионо.
- ○ Гамшгаас сэргийлэх хорооноос энэхүү тэмдэглэлт ажлын хүрээнд дараагийн хурлыг 1 дүгээр сард зохиохоор судалж байна.

Тэмдэглэлт арга хэмжээ (1 сарын 17-ны өдрийн цуглаан, дурсгалын парк, харилцааны өдөрлөг, гамшгаас сэргийлэх сургуулилт г.м)

NEAR
4-1. Хёго мужийн аялал жуулчлалын нөөц
HYOGO PREFECTURE
Химэжи цайз
Такэда балгас
Акаши дүүжин гүүр
Арима халуун рашаан

NEAR
4-2. Хёго мужийн аялал жуулчлалын нөөц (Хоол унд)
HYOGO PREFECTURE
Кобэ үхрийн мах
Кобэгийн амттан
Далайн бүтээгдэхүүн (хавч, загас)
Япон архи (Японд архи үйлдвэрлэлээр тэргүүлдэг)

NEAR
HYOGO PREFECTURE
Баярлалаа.
Хёго мужийн лого
"Хабатан"

NEAR Холбооны Боловсрол, соёлын харилцааны хорооны үйл ажиллагаа

"Зүүн хойд Азийн харилцааны жигүүр 2014" арга хэмжээ

"Зүүн хойд Азид хамтдаа оршин тогтнох нь"

Шиманэ мужийн Байгаль орчин, амьдралын ямны соёл, олон улсын хэлтсийн дарга Вакацки Шинжи

1. Ерөнхий зүйл (1)

Зорилго:

- Зүүн хойд Азийн бүсийн хүүхэд, залуучуудад зориулсан харилцаа, хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдний хоорондын харилцан ойлголцол, нөхөрлөлийг бататгаж бэхжүүлэх.
- Зүүн хойд Азийн бүсийн харилцаа, хамтын ажиллагааны шинэ сүлжээг бий болгох

Зохион байгуулагч: Япон улсын Шиманэ муж
Дэмжигч байгууллага: NEAR Холбоо

2. Ерөнхий зүйл (2)

Хөтөлбөрийн сэдэв:
"Зүүн хойд Азид хамтдаа оршин тогтнох нь"

Оролцогчид тавигдах шаардлага:

- ❖ Зүүн хойд Азийн бүсийн 18-30 насны хүүхэд залуус оролцоно.
- ❖ (Мөн Шиманэ мужийн хүүхэд залуусыг хамруулах ба нийт 30 гаруй оролцогч)
- ❖ (Япон хэлээр харилцах чадвартай байх)

※2004 онд "Зүүн хойд Азийн харилцааны жигүүр" арга хэмжээ эхэлсэн бөгөөд 10 жилийн хугацаанд нийт 236 хүн Шиманэ мужид айлчилсан.

3. Хөтөлбөр

2014.8.1～8.6

Өдөр	AM・PM	Агуулга
8/1	PM	Нээлтийн ажиллагаа Оролцогчид өөрсдийгөө танилцуулах, Шиманэ мужийн танилцуулга
8/2	AM PM	Япон айлд байрлах, танилцах Хүлээн авалт, байрласан айлдаа зочлох
8/3	Бүхэл өдөр	Япон айлд байх
8/4	Бүхэл өдөр	Хотоор аялах, японы соёлтой танилцах хөтөлбөр
8/5	AM PM	Санал бодол солилцох хэлэлцүүлэг Үдэлтийн арга хэмжээ, оройн хоол
8/6	AM	Зочдыг үдэх (Арга хэмжээ өндөрлөх)

4. “Харилцааны жигүүр” арга хэмжээний үеэр

Анхаарал тавьсанд баярлалаа.

GTI
2014 Шинэ Зүүн хойд Азийн зуун – Хамтын ажиллагаа, хөгжил, хамтдаа орших !
2014 GTI
Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн
GTI International Trade & Investment
Канвон мужийн захиргааны глобал бизнесийн алба
Мин Бён Ду

I
GTI "Олон улсын худалдаа, хөрөнгө
оруулалтын үзэсгэлэн"-гийн тухай

АГУУЛГА
I GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн
II 2013 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн" -гийн үр дүн
III 2014 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн" -гийн төлөвлөгөө

1. Үүсгэн байгуулсан түүх, зорилго
Үүсгэн байгуулсан түүх
2011.9
GTI Орон нутгийн хамтын ажиллагааны хороог байгуулсан
Засгийн газар болон орон нутаг хооронд хамтын ажиллагааны системийг байгуулсан.
Орон нутгийн захиргаад GTI-ийн үйл ажиллагаанд оролцох болсон.
Зүүн хойд азийн орон нутаг хооронд эдийн засаг, хамтын ажиллагаа явуулж бүсийн эдийн засгийг хөгжүүлнэ.
GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн зохиосон.
GTI Бүс орон нутгийн бодит эдийн засгийн хамтын ажиллагаа явуулна.
Зорилго
Харилцан хөрөнгө оруулалт хийх
Худалдааг өргөжүүлэх
Харилцан аялал жуулчлалын харилцаа явуулах
Эдийн засгийн харилцаа хамтын ажиллагааны суурийг тавина
Бодит харилцаа, хамтын ажиллагааг явуулснаар хамтын хөгжлийг бий болгоно.

2. Үйл ажиллагааны чиглэл, хүлээж буй үр дүн

- Үйл ажиллагааны чиглэл

GTI-ийн гишүүн орнуудын орон нутгийн захиргаадад бүхээг үнэгүй	GTI-ийн бүс нутгийн павилон, компанийн бүтээгдэхүүний павилон, аялал жуулчлалын сурталчилгааны павилон	Улс орнууд бүрийн бизнесийн өдөрлөг, хөрөнгө оруулалтын орчныг танилцуулах хөтөлбөр, худалдаа хөрөнгө оруулалтын зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулна.	GTI Олон улсын үзэсгэлэнг БНСУ-ын төлөөлөх гол үзэсгэлэн болгоно.	Зүүн хойд азийн бүс тогтмол үзэсгэлэн зохиох, харилцан оролцох зэргээр хамтын ажиллагааны системийг байгуулах

- Хүлээж буй үр дүн

GTI бүс нутгийн хооронд хамтын ажиллагааны шинэ загварыг гаргана. → Зүүн хойд азийн орон нутаг хооронд бодит эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлнэ. → Өмнөд Солонгос ба GTI бүс хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэн хамтын хөгжилд хүрнэ.

II 2013 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн" -гийн үр дүн

2013 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн"-гийн үр дүн

Сэдэв	Зүүн хойд Азийн шинэ зуун-Хамтын ажиллагаа, хөгжил, хамтдаа оршин тогтнох
Хугацаа	2013. 6. 9 ~ 6.12
Агуулга	**Оролцогч** : GTI бүсийн гишүүн 10 гаруй орон, Самсунг, Поско зэрэг дотоод гадаадын 520 компани, худалдааны компани зэргийн 3700 хүн **Гол арга хэмжээ:** - Бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, худалдаа хөрөнгө оруулалтын зөвлөлдөх уулзалт, хөрөнгө оруулалтыг татах тухай танилцуулга - GTI олон улсын хамтын ажиллагааны форумын Аялал жуулчлалын хорооны хурал - Солонгосын жижиг дунд аж үйлдвэр эрхлэгчдийн хурал (1500 хүн оролцсон) - Дэлхийн худалдаа, аж үйлдвэр эрхлэгч солонгос үндэстний хурал (200 хүн оролцсон)
Зохион байгуулагч	Ганвон муж, GTI удирдах газар
Ивээн тэтгэгч	БНСУ-ын Төлөвлөлт, санхүүгийн яам, Аж үйлдвэр худалдаа, нөөцийн яам, Гадаад харилцааны яам, БНСУ-ын худалдааны нийгэмлэг, KOTRA, Хөдөө аж ахуй далайн бүтээгдэхүүний газар

2013 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн" -гийн үр дүн

Гол үр дүн

GTI-ын гишүүн орнуудын хамтын ажиллагаа, дэмжлэгээр анх удаа зохиогдсон.

- Зүүн хойд Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүтээл, шинэ загварыг бий болгосон.
- Солонгосын үзэсгэлэн арга хэмжээний түүхэнд гадаадын компани хамгийн ихээр буюу нийт оролцогчдын 21%-ийг эзэлж байсан.
- Хятадын олон улсын худалдааг идэвхжүүлэх хороо, Хятадын аж ахуй эрхлэгчдийн холбоо, ОХУ дахь Солонгосын төлөөлөгчийн газар, Дэлхийн солонгос үндэстэн бизнес эрхлэгчдийн холбоо, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн глобал Хан үндэстэн Холбоо, Хятадын аж ахуй эрхлэгч Жусон үндэстний нийгэмлэг, Оросын Алс Дорнодын эдийн засгийн байгууллага зэрэг олон байгууллагууд оролцсон.

Дотоод гадаадын төрийн байгууллагын төлөөлөл оролцсон.

- Солонгосын парламентын тэргүүлэгч Ган Чан Хи тэргүүтэй парламентын гишүүд болон Төлөвлөлт, санхүүгийн яамны өндөр албаны хүмүүс оролцсон. Солонгосын ерөнхий сайд Жон Хун Вон нээлтийн ажиллагаанд зориулан видео мэндчилгээ илгээсэн.
- Монгол улсаас БНСУ-д суугаа Элчин сайд, Төв аймгийн Засаг дарга, Зүүн Казакстаны парламентын дарга, Приморын хязгаарын захирагчийн орлогч, Тоттори мужийн захирагчийн орлогч зэрэг гадаадын өндөр албаны хүмүүс оролцсон.

III 2014 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн" -гийн төлөвлөгөө

2014 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн"-гийн төлөвлөгөө

Сэдэв — **Шинэ зууны хойд Азийн зуун-Хамтын ажиллагаа, хөгжил, хамтдаа оршин тогтнох**

Хугацаа — 2014.10.23 ~ 10.26

Гол арга хэмжээ

10.23	10.24	10.25	10.26
- Нээлтийн ажиллагаа – Аж ахуй эрхлэгч дэлхийн солонгос үндэстнүүдийн уулзалт хурал -Худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалт	- GTI Олон улсын хамтын ажиллагааны форум - Худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалт	- Харилцаат нутгуудын өдөр - Худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалт	- Шилдэг бүтээгдэхүүний шагнал -Худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалт

Хаана — **Ганнэн хот**

2014 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн"–гийн төлөвлөгөө

Цар хүрээ — 500 гаруй компани, Дотоод гадаадын 10000 гаруй бизнес эрхлэгч

- **Оролцогч:** GTI-ийн гишүүн орнууд/Монгол, ОРос, Өмнөд Солонгос, Хятад/ болон Хойд Солонгос, Япон, Төв Азийн 10 гаруй орон
- **Үзэсгэлэнгийн чиглэл:**
  - Дэвшилтэт технологи, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн
  - Амьд биет, эм, БИБ, гоо сайхан зэрэг биологийн бүтээгдэхүүн
  - Эмнэлэг, хувь хүний зориулалт бүхий эмчилгээний төхөөрөмж
  - Органик бүтээгдэхүүн
  - Аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь бүсийн сурталчилгаа явуулах : Үүнд: Хятадын Чанцытуны павилон, Оросын Алс Дорнодын стратегийг танилцуулах павилон
- **Үзэсгэлэн арга хэмжээ:**
  - Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа: Улс, бүс бүрийн хөрөнгө оруулалтын орчинг танилцуулах, худалдаа хөрөнгө оруулалтын зөвлөлдөх уулзалт
  - Бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа: Дотоод гадаадын брэнд, шинэ технологи, дэвшилтэт бүтээгдэхүүний үзэсгэлэн, улс бүрийн бизнесийн өдөрлөг зохион явуулна. Улс бүрийн үндэсний урлагийн тоглолт, нэртэй бизнесменүүдийг урьж оролцуулсан уулзалт болно.

Зохион байгууллагч — Ганвон муж

Ивээн тэтгэгч — БНСУ-ын Төлөвлөлт, санхүүгийн яам, Аж үйлдвэр худалдаа, нөөцийн яам, Гадаад харилцааны яам, БНСУ-ын Худалдааны нийгэмлэг, KOTRA, Хөдөө аж ахуй далайн бүтээгдэхүүний газар

2014 "GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн"-гийн төлөвлөгөө

Гишүүн орнуудад дараахь тусгай хөнгөлөлтийг үзүүлнэ

- Оролцогч компанидад бүхээг үнэгүй.
  -Арваас дээш компани оролцоход унаагаар үйлчилнэ.
  -Бүхээг ажиллуулах компанидийг Солонгосын компанидтай уулзахад зуучилна.
  ※ Солонгост улстай худалдаа, хөрөнгө оруулалт хийхийг хүсч буй компани, аж үйлдвэр эрхлэгчид багаар оролцож болно.
- Захирагчийн орлогчоос дээш албан тушаалтан оролцсон тохиолдолд байр хоолны зардлыг Ганвон муж хариуцна (3 хүртэлх хүний)

Гишүүн орнуудын оролцох хэлбэр

- Гишүүн орнуудын засгийн газрын төлөөлөл оролцох
- Гишүүн орны компаниудийн павилон, сурталчилгааны павилон ажиллуулах
- Худалдаа, хөрөнгө оруулалтын уулзалтад оролцох

Оролцох хүсэлт хүлээж авах

Хүсэлт хүлээж авах хугацаа: 2014 оны 5 сарын сүүл
Харилцах утас: 82 – 33 - 249 - 2949 , И-мэйл хаяг: hjchoe83@korea.kr
Вэбсайт : www.gtiexpo.org

Баярлалаа

COP12 / MOP7
PYEONGCHANG KOREA 2014

Биологийн олон янз байдлын тухай конвенцийн гишүүн орнуудын 12 дугаар чуулга уулзалт

Ганвон мужийн глобал
төслийн алба
Мин Бён Ду

Biodiversity for Sustainable Development

Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Ерөнхий зүйл

Чуулга уулзалтын нэр — Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт (CBD COP-12)

Уриа

- Тогтвортой хөгжлийн төлөөх биологийн олон янзын байдал (Biodiversity for Sustainable Development)
- Биологийн олон янзын байдлыг хамгаалснаар тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах талаарх нийгмийн ухамсар ойлголтыг олон улсын хэмжээнд нэмэгдүүлэх
- 2015 оноос хойш НҮБ олон улсын хөгжлийн зорилт болон тогтвортой хөгжил SDG(Sustainable Development Goals)-ийг хэлэлцэхэд амьд биетийн олон янзын байдлыг онцолсон.

Зохиогдох хугацаа — **2014. 9. 29 ~ 10. 17**

Ангилал	Хугацаа
Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт (COP12)	2014. 10. 6 ~ 10. 17
Нагоягийн протоколийн гишүүн орнуудын 1-р хурал (COP MOP1) *Нагоягийн прокол хүчин төгөлдөр болсон тохиолдолд	2014. 10. 6 ~ 10. 17
Биологийн аюулгүй байдлын протоколийн гишүүн орнуудын 7-р хурал (COPMOP7)	2014. 9. 29 ~ 10. 3

2

Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Болох газар — Ганвон мужийн Пёнчан Альпенсиа арга хэмжээний төв

Оролцох хүрээ — 20000 гаруй оролцогч (193 гишүүн орны төлөөлөгч, олон улсын байгууллага, аж үйлдвэр, ТББ-ын төлөөлөл)

Хурал арга хэмжээ

Ангилал	Агуулга
Гишүүн орнуудын чуулга уулзалт (COP)	• Төр засгийн төлөөлөл хоорондын албан ёсны яриа хэлцэл хийгдэх хурал учир гэрээ хэлцэл хийх зэрэг томоохон шийдвэр гаргах дээд хэмжээний хурал болно.
Протоколийн хурал (COP-MOP)	• Төр засаг хоорондын хэлэлцээр хурал бөгөөд протоколийн талаарх шийдвэр гаргах хурал
Дээд хэмжээний хурал (High level Segment)	• Энэ хурлыг чуулга уулзалтын сэдэв болон гол шийдвэрлэх асуудалтай холбоотой сэдвээр гишүүн орон удирдан зохион байгуулдаг.
Нэмэлт арга хэмжээ (Side Event)	• Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон форум, семинар, үзэсгэлэн арга хэмжээг зохионо.

3

Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Гишүүн орнуудын чуулга уулзалтын гол хэлэлцэх асуудал

1 Глобал биологийн олон янзын байдлын зорилтын явцын хэрэгжилтийг шалгах болон зааварчилга гаргах

- Амьд биетийн олон янз байдлын талаарх 20 зорилтыг 2020 он хүртэл хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явцын шалгалтыг хийнэ.
- Зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх аргачлал болон цаашид мөрдөх зааварчилгааг гаргана.

2 Нагоягийн протоколийг хэрэгжүүлэх тогтолцоог байгуулах (Нагоягийн протоколийн гишүүн орнуудын анхдугаар хурал зохиох

3 Тогтвортой хөгжил ба амьд биетийн олон янз байдал

- "Post-2015" тогтвортой хөгжлийн зорилт гаргах

4 Конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд гол гол үйл ажиллагаанд үнэлгээ хийж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох

- Хамгаалах бүсийг тогтоох, экологийг сэргээх, далайн экологийг хамгаалах зэрэг төрөл тус бүрийн талаар үнэлгээ хийж, зааварчилгаа гаргах, шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах, хөгжиж буй орнуудын чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга замын талаар хэлэлцэх

4

Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Албан ёсны лого

Хүн байгалийн шүтэлцээг чухалчлах солонгос маягийн сэтгэлгээнд үндэслэсэн.

Тэнгэр(тогоруу), далай(халим), газар(янгир)-аар экологийг илтгэх ба логоны төв дунд хүнийг Мёбиусын цагаригаар холбон шүтэлцээ, зохицолдоготоой байж тогтвортой хөгжинө гэдгийг илэрхийлсэн.

Тогтвортой хөгжил ба хязгааргүйг илтгэх тойрог нь хүн байгалийн шүтэлцээ, амь амьдралын эх үүсэл болох дэлхийн бөмбөрцгийг дүрсэлсэн.

5

“Амьд биетийн олон янз байдал” сэдэвт дэлхийн орон нутгийн захирагч нарын хурал

Орон нутгийн захиргаадын олон улсын харилцааны нийгэмлэг(ICLEI Канвон муж)

- Хурлын нэр : Амьд биетийн олон янз байдлын дэлхийн орон нутгийн захирагч нарын хурал
- Уриа : Амьд биет оршин тогтвортой хөгжлийн хот
- Хугацаа : 2014.10.12 ~ 10.14

Хөтөлбөр

- Үдэсан уул, Гёнпу нуурын намагт газраар аялах
- Хот, төвлөрсөн газарт амьд биетийн олон янз байдлыг нэмэгдүүлэхийн тулд бодит жишээ бүхий илтгэл тавих
- Амьд биетийн олон янз байдлыг бодитоор бий болгоход орон нутгийн захирагч нарын үүрэг оролцооны тухай хэлэлцэх

- Оролцогч : 500 (Орон нутгийн захиргаадын захирагч, мэргэжилтэн, ТББ гм)

Биологийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Гол стратеги: Амьд биетийн олон янз байдлыг хэлэлцэх, зорилтыг хэрэгжүүлэх

Нагоягийн протоколийг хүчин төгөлдөр болгох

2015 онд НҮБ амьд биетийн олон янз байдлын тогтвортой хөгжүүлэх зорилт гаргана

2011~2020

Амьд биетийн олон янз байдлын стратегийг эрчимтэй хэрэгжүүлэх Зорилгодоо хүрэх

Пёнчаны зорилт хөтөлбөр гаргах

Korea Biodiversity Initiative дэмжлэгээр Пёнчаны тунхаг гаргах

Олон улсын амьд биетийн олон янз байдлыг нэмэгдүүлэх

CBD COP12

6

Оролцох арга, лавлах

COP12 / MOP7 PYEONGCHANG KOREA 2014

Амьд биетийн олон янз байдлын конвенцийн гишүүн орнуудын 12-р чуулга уулзалт

- http://mev.global-it.kr/cbdeng/index
- Бүртгэх : Чуулган зохион байгуулах албa руу оролцох хүсэлт явуулах

Mr. Braulio Ferreira de Souza Dias
Executive Secretary
Secretariat of the Convention on Biological Diversity
413 St. Jacques Street West, Suite 800 Montreal, Quebec
H2Y 1N9 Canada Fax: +1-514-288-6588
E-mail: secretariat@cbd.int

Дэлхийн орон нутгийн захиргаадын захирагч нарын хурал

- Лавлах : Орон нутгийн захиргаадын олон улсын харилцааны нийгэмлэг(ICLEI Канвон муж)

Утас: +82-70-7777-8695
Цахим шуудан:



NEAR Холбооны био эмчилгээний аж үйлдвэрийн хорооны анхдугаар хурлын зар

Чүнчонбүг мужийн Био
хөгжлийн хэлтэс

□ Арга хэмжээний тойм

○ Хугацаа : 2014 оны 9 сарын 29-ний өдрөөс 10 сарын 2-ний өдрийг хүртэл

○ Хугацаа : 2014 оны 9 сарын 29-ний өдрөөс 10 сарын 2-ний өдрийг хүртэл

○ Сэдэв : Зүүн хойд Азийн бүсийн био, эмчилгээний аж үйлдвэрийн харилцаа, хамтын ажиллагаа

○ Оролцогч : Холбооны гишүүн орон нутгийн 50 төлөөлөгч

Ангилал	Нийт	Өмнөд Солонгос	Хятад	Япон	Монгол	Орос
Хуралд оролцогчдийн тоо	50	20	8	6	10	6

○ Ерөнхий хөтөлбөр

Өдөр	Агуулга	Дэлгэрэнгүй
9. 29	Зочид ирэх	Бүртгэл
9. 30	Хурал (3 давхарт Жигжи танхим) Хүлээн авалт (3 давхарт Үам танхим)	• Хурлын сэдэв : Зүүн Хойд Азийн бүсийн био эмчилгээний аж үйлдвэрийн харилцаа, хамтын ажиллагаа Нээлтийн үг : Чүнчонбүг мужийн захирагч Чүнчонбүг мужийн захиргаа, Холбооны хэрэг эрхлэх газар, гишүүн орон нутгийн төлөөлөл мэндчилж үг хэлнэ Баярын мэндчилгээ: Био байгаль орчны газрын дарга
10. 1	Аялал	• Олон улсын Био аж үйлдвэрийн экспо, Чоннамдэ үзэх
10. 2	Зочдыг үдэх	• Зочид буцах

○ Гишүүн орон нутгуудийн илтгэлийн сэдэв: Орон нутгийн био эмчилгээний аж үйлдвэрийн чиглэлийн амжилттай хэрэгжүүлсэн амжилт, туршлага

○ Илтгэл тавих орон нутаг : Монгол, Орос, Хятад, Япон

□ Дэлгэрэнгүй хөтөлбөр

Өдөр	Цаг	Агуулга	Тайлбар
9/29	14:00	· Check in	Рамада зочид буудал
	18:00 ~ 20:00	· Оройн хоол, амралт	3 давхарт Жүсон танхим
9/30	09:00 ~ 09:30	· Хурлын бүртгэл	
	09:30 ~ 12:00	Нээлтийн ажиллагаа: - Нээлтийн үг/Кёнсанбүг мужийн захирагч - Баярын мэндчилгээ(NEAR Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга) - Чүнчонбүг мужийн видео танилцуулга -"БНСУ-ын био эмчилгээний аж үйлдвэрийн өнөөгийн байдал" танилцуулга -Чүнчонбүг мужийн био эмчилгээний аж үйлдвэрийн танилцуулга - Гишүүн орон нутгуудийн илтгэл, дурсгалын зураг авахуулах	Жигжи танхимд - 4 хэлээр шууд орчуулга хийнэ
	12:20 ~ 13:10	Өдрийн хоол	3 давхарт Жүсон танхимд
	13:20 ~ 15:00	- "Олон улсын био экспо" арга хэмжээний видео танилцуулга - Хятад, Японы орон нутгуудийн илтгэл	
	15:00 ~ 15:20	Coffee Break	
	15:20 ~ 18:00	- Монгол, Оросын орон нутгуудийн илтгэл - Олон улсын хамтарсан судалгаа буюу био аж үйлдвэрийн талаарх жишээ илтгэл - Хэлэлцүүлэг, хурлын дүгнэлт	
	18:00 ~ 20:00	Хүндэтгэлийн хүлээн авалт - Мэндчилгээ, хундага тулгаж үг хэлэх - Монгол, Орос, Хятад, Японы төлөөлөгч үг хэлэх	3 давхарт Үам танхим
10/1	09:00 ~ 12:00	Чоннамдэ (Ерөнхийлөгчийн зуслан) үзэх	
	12:00 ~ 13:30	Өдрийн хоол	
	13:30 ~ 18:00	Олон улсын био аж үйлдвэрийн экспо	
	18:00	Оройн хоол, чөлөөт цаг	
10/2	08:00 ~	Арга хэмжээ өндөрлөх, зочид буцах	

□ Оролцох хүсэлт хүлээж авах

2014 оны 7 сарын сүүл хүртэл хүлээж авна. Гишүүн орон нутаг бүрээс 2 хүн оролцох боломжтой

Холбооны Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын хорооны хурал 2014 оны 7 дугаар сарын 18-нд болох тухай

Магадан мужийн захиргаа

Хүндэт нөхөд өө,

Зүүн Хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын Холбооны Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын хорооны хурал энэ 2014 оны 7 сарын 18-ны өдөр ОХУ-ын Магадан мужид зохион байгуулагдана

Хурал болох газар: ОХУ-ын Магадан мужийн Магадан хот
Хуралд оролцох хүсэлт хүлээн авах хугацаа: 2014.06.15
Зохион байгуулагч: Магадан мужийн Эдийн засгийн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого, Инновацийн Яам

Магадан муж нь Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын хорооны зохицуулагчаар ажилладаг бөгөөд Хятад, Монгол, Япон, Солонгос улсын хамтран ажиллагчид, найз нөхөд та бүхнийг энэ удаагийн хуралд өргөнөөр оролцохыг урьж байна.

Энэ хурлаар бид эрдэс баялгийн талаар харилцан мэдээлэл солилцох, уул уурхайн компаниудыг татан оролцуулах, бүс нутагтаа байгалийн баялгийг хамтран эзэмшихтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэх боломжтой учир манай бүс нутгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болно гэж үзэж байна.

Манай Магадан муж нь ОХУ-ын зүүн хойд хэсэгт оршдог бөгөөд баруун хойд талаараа Сахагийн БНУлс, баруун талаараа Хабаровскийн хязгаар, хойд болон зүүн хойд талаараа Чукотскийн автономит дүүрэг, зүүн хэсгээрээ Камчаткатай хиллэн оршдог бөгөөд өмнөд хэсгээрээ Анчин тэнгис /Охотский море/-тэй хил залгадаг.

Манай Магадан муж нь эртний арвин баялаг уламжлал бүхий дэлхийн уул уурхайн үйлдвэрлэлийн тэвүүдийн нэг бөгөөд төрөл бүрийн байгалийн эрдэс, ашигт малтмалын арвин их нөөц нь мужийн хөгжлийн гол үндэс суурь болохын зэрэгцээ гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг ихээр татах боломжийг бүрдүүлсэн байдаг.

Ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа эрхлэгч компаниуд нь мужийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 76%-ийг үйлдвэрлэж, мужийн төсөвт нийт татварын орлогын 15,3%-г оруулж, тус салбарт ажиллагсад нь нийт ажиллагсдын 16%-ийг эзлэхийн зэрэгцээ зөвхөн энэ салбар нь мужийн ДНБ-ний 18,7%-ийг дангаараа бүрдүүлдэг.

Тус мужийн газар нутаг нь нийтдээ 4,2 мянган тонн алт, 43,8 мянган тонн мөнгө, 8,7 тэрбум тонн нүүрс, 86,9 тэрбум тонн өнгөт метал, 2 тэрбум орчим тонн хар төмөрлөг, 4,0 тэрбум тонн нүүрс, 510 тэрбум тонн цемент болон гипс, 350 тэрбум м3 түгээмэл тархацтай ашигт малтмал гэх мэт төрөл бүрийн эрдэс баялгийн нөөцийг агуулсан газар юм.

ОХУ-ын Шинжлэх ухааны Академийн Алс Дорнод дахь салбарын Н.А.Шилогийн нэрэмжит Хойд-Дорнын иж бүрэн судалгаа-шинжилгээний институтаас боловсруулсан аргачлалаар Магадан мужийн нөөц баялгийн геологи-эдийн засгийн үнэлгээг хийж үзэхэд 2013 оны байдлаар тус мужийн газрын хэвлий дэх баялгийн өртөг 126,8 триллион рубль буюу 4 триллион доллараар хэмжигдэж байсан байна.

Тэр дундаа энэ мөнгөн дүнгийн 46,3%-ийг нүүрсустөрөгч, 4,8%-ийг нүүрс, 15.8%-ийг өнгөт металл (10,9%) болон хар төмөрлөг (4,9%), бусад ашигт малтмал 2,6 хувь, харин мужийн өнөөгийн эдийн засгийн гол үндэс тулгуур болсон үнэт металл 10,5%-ийг тус тус бүрдүүлж, голлох байр суурийг эзэлж байна.

ОХУ-ын үнэт металлын нөөцөд эзлэх хэмжээгээр авч үзвэл улсын нийт алтны нөөцийн 18%, мөнгөний нөөцийн 16% нь Магадан мужид байна.

Манай Магадан мужид болох Эрдэс баялаг ашиглалт, зохицуулалтын хорооны хурал нь та бидний зөвхөн байгалийн эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах төдийгүй, бусад салбарт мөн байнгын харилцаа холбоо тогтооход ихээхэн тус дөхөм болно хэмээн найдаж байна.

Гишүүн орон нутгуудын захиргааны удирдлагууд, Хөгжлийн бодлого, стратегийн хэлтэс, Уул уурхайн хэлтсийн дарга нар, Уул уурхайн үйлдвэр, Хөрөнгө оруулалтын компаниудын захирлуудыг 2014 оны 7 дугаар сарын 18-ны өдөр болох NEAR Холбооны Эрдэс баялгийн ашиглалт, зохицуулалтын хорооны хуралд өргөнөөр оролцохыг урьж байна.

Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын Холбоотой хамтран ажиллах санал

Говь-Алтай аймгийн Иргэн, нийгмийн хөгжлийн
бодлого эрхэлсэн орлогч Д.Батсайхан

Сайн байцгаана уу.

Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жэ Хю, алс холоос хүрэлцэн ирсэн гишүүн байгууллагуудын төлөөлөгчид өө.

Хуралд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид та бүхэнд чин сэтгэлийн баяр хүргэе.

Эдийн засгийн даяаршлыг дагаад улс хоорондын харилцаа өдрөөс өдөрт нягтарч, улмаар Зүүн Хойд Азийн бүсийн хурдацтай хөгжил нь дэлхийн эдийн засгийн тавцанд өдрөөс өдөрт өсч байна.

Зүүн хойд Азийн Засаг Захиргаадын холбоо 1996 онд байгуулагдсанаас хойш өнөөг хүртэлх хугацаанд Зүүн хойд Азийн 6 улсын 70 гаруй орон нутгаас бүрдсэн Зүүн Хойд Азидаа хамгийн том олон улсын байгуулага болон өргөжиж, нийгмийн томоохон салбаруудад харилцаа, хамтын ажиллагааг өрнүүлж ихээхэн амжилтад хүрч байгааг энд сайшаан тэмдэглэхэд таатай байна.

Монгол улс, тэр дундаа Говь-Алтай аймаг тус холбооны гишүүнээр 2006 онд элсэн орсноос хойш холбоо болон түүний дэд хороодоос зохион байгуулсан олон улсын арга хэмжээнд идэвхитэй оролцож, тодорхой үр дүнд хүрсэн билээ.

Говь-Алтай аймаг нь Монгол улсдаа газар нутгийнхаа хэмжээгээр 2-рт ордог, Монгол орны баруун урд хэсэгт орших 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, хойд талаараа Завхан, зүүн талаараа Баянхонгор, баруун талаараа Ховд аймаг, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай тус тус хиллэдэг.

Засаг захиргааны 18 сум, 83 багтай. Аймгийн төв Алтай хот нь улсдаа хамгийн өндөрт буюу далайн түвшнээс дээш 2181метрийн өндөрт оршдог, жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, уур амьсгалын онцлогтой аймаг юм. Тус аймагт 15.2 мянган өрхөд 54,9 мянган хүн оршин сууж байгаагаас 7,0 мянган өрх буюу 45.0 хувь нь малчин өрх юм. Аймагт мал, аж ахуй харьцангуй сайн хөгжсөн харин сүүлийн жилүүдэд газар тариалан эрхлэх иргэдийн тоо өсөж байна.

Мөн сүүлийн үед уул уурхайн салбар нилээд хөгжиж одоогоор аймагт төмрийн хүдрийн, алтны, сайн чанарын нүүрсний уурхайнууд ажиллаж байна.

Манай аймаг дэлхийд ховордсон ан амьтад, эмийн ховор зүйлийн ургамлаар арвин бөгөөд ээргэнэ, хунчир, чихэр өвс зэрэг эмийн ургамлыг тарималжуулах ажил хийгдэж байна.

Иймд та бүхнийг говь, хангай, тал хээр хосолсон манай аймагт айлчлахыг урья. Алтай нутгийн ард иргэд Зүүн хойд Азийн анд нөхөд та бүхнийг халуун дотноор угтах болно.

Бид цаашдын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бүсийн хамтын ажиллагааны холбогч гүүр болох NEAR холбоогоор дамжуулан бүсийн хөгжил дэвшилд улам их хувь нэмэр оруулахын төлөө хичээхийн зэрэгцээ дараах хамтран ажиллах саналыг тавьж байна.

1. Монгол улсын баруун бүс нутгийг эмч, эмнэлгийн мэргэжилтнээр хангах зорилготой Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн салбар аймагт үйл ажиллагаатай явуулдаг бөгөөд “Бигэрийн 5 элсний бөөрний сувилал”, Энергийн уул гэх мэт орчин үеийн анагаах ухааныг уламжлалт анагаах ухаантай хослуулсан өвөрмөц эмчилгээтэй энэ салбарт хамтран ажиллах.

2. Холбооны гишүүн орон нутгийн Захиргаад хооронд ах дүүгийн болон эгч дүүгийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг байгуулах ажлыг зохион байгуулах, мөн олон улсын чанартай арга хэмжээнүүдийг орон нутагт зохиоход дэмжлэг үзүүлэх.

Цаашид Холбооны гишүүн байгууллагуудтай эрчим хүч, аялал жуулчлалын салбарт ажиллахдаа таатай байх болно.

Эцэст нь Холбоо хөгжин дэвжихийг хүсэн ерөөхийн ялдамд хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

2014 NEAR
Холбооны 10-р Бүгд хурлын зар

NEAR Working-level
Workshop 2014

2014 NEAR Холбооны 10-р Бүгд хурлын зар

БНСУ-ын Жолланам мужийн захиргаа

Олон улс, хамтын ажиллагааны хэлтэс

Сайн байцгаана уу

БНСУ-ын Жолланам мужийн Олон улс, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Юү Хён Ху байна.

Та бүхэнтэй уулзаж байгаадаа туйлын баяртай байна.

Жолланам муж Зүүн хойд Азийн 6 орны 71 орон нутаг хооронд харилцааг нэмэгдүүлэх хамтын хөгжил дэвшлийг эрчимжүүлэхийн тулд NEAR Энэ удаа зохиогдох Бүгд хурлаар 18 жилийн түүхтэй ЗХАБНЗЗХ-ны гишүүн улс, орон нутгийн нийтлэг асудлыг ухаалгаар шийдвэрлэж, Зүүн хойд Азийн хамтын хөгжлийн суурийг тавих юм бол жинхэнэ түншлэлийн харилцааг тогтоож чадах юм.

Жолланам муж 2012 онд Ёосү-Дэлхийн үзэсгэлэн, 2013 онд Сүнчоны булан-Олон улсын цэцэрлэгийн үзэсгэлэнг амжилттай зохиосон туршлагад үндэслэн төрөл бүрийн салбарын олон улсын арга хэмжээг зохиож, гадаад харилцааг өргөжүүлэх зэргээр олон улсын чанартай хот болохыг хичээж байна.

Ж олланам мужид болох NEAR Холбооны 10-р Бүгд хуралд та бүхнийг өргөнөөр оролцохыг хүсье.

Баярлалаа.

“Хятад, Солонгос, Японы орон нутгийн захиргаадын 16-р хурлын зар

NEAR Working-level Workshop 2014


Хятад, Солонгос, Японы орон
нутгийн захиргаадын 16-р хурал
2014. 5. 22
경상북도
GYEONGSANGBUK-DO
구 미 시


Дараалал
1. Хурлын танилцуулга
2. Гол хөтөлбөр
3. Дэлгэрэнгүй хөтөлбөр
4. Арга хэмжээ болох газар


3
1. Хурлын танилцуулга
Хурлын нэр
Хятад, Солонгос, Японы орон нутгийн захиргаадын 16-р хурал
Хугацаа
2014.9.1~4
Г а з а р
Гүми хот, Кёнсанбүг муж
Зохион байгуулагч
Солонгосын хот, мужийн захирагч нарын зөвлөл, Кёнсанбүг муж, Гүми хотын захиргаа
Хамтрагч
Хятадын иргэдийн гадаадтай харилцах нийгэмлэг, Японы орон нутгийн глобалчлалын нийгэмлэг
Ивээн тэтгэгч
Солонгосын хот, сум, дүүргийн захирагч нарын зөвлөл, NEAR Холбоо


4
1. Хурлын танилцуулга
Хурлын сэдэв
Сэдэв
Хятад, Солонгос, Японы харилцааг хүмүүнлэгийн харилцаагаар дамжуулан идэвхжүүлэх нь
Дэд сэдэв
1) Орон нутгийн захиргаадын олон улсын арга хэмжээнд харилцан өргөнөөр оролцсноор аялал жуулчлал соёлын харилцаа идэвхжих нь
2) Бүсийн эдийн засгийг идэвхжүүлэхийн тулд эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэх арга зам
Оролцох хүрээ
Хятад, Солонгос, Япон 3 улсын төлөөлөх байгууллага(GAOK, CPAFFC, CLAIR)-уудын төлөөлөл болон холбогдох хүмүүс
Дээрх 3 улсын хот, мужийн захирагч нар, төрийн албан хаагчид
Холбогдох бусад байгууллагуудын төлөөлөл



Аялах газрын танилцуулга

NEAR Working-level Workshop 2014

Аялах газрын танилцуулга

I. Дунхуаса сүм

◦ Товч танилцуулга

• Шилла улсын үеийн 493 онд баригдсан. Дунхуаса нь дунхуа-модноос цэцэг дэлбээлэх, са- сүм гэсэн утгатай. Шилла улсын үед тэр хавийн модноос цэцэг их дэлбээлснээс үүдэлтэй нэр юм.
Дэгү хотын зүүн хойд зүгт орших Пальгунсан уулын урд хэсгээр байрладаг. Бурханы шашны хөшөө, сэрэг дүрийг эндээс үзэж болох ба тухайлбал 33 м өндөр бурханы хөшөө бий.

II. Бёнсан совон

◦ Товч танилцуулга

Жусон улсын үеийн Күнзийн шашны төлөөлөх барилга бөгөөд Күнзийн ухааны эрдэмтэн Рю Жон Рюн күнзийн сургаал номлолыг заадаг байсан газар юм. Уг газарт түүний бичсэн номноос авахуулаад 1000 гаруй төрлийн 3000 гаруй ном зохиол хадгалагдаж байна.
Рү Сон Рюнийг нас эцэслэсний дараа шавь нар нь түүнийг дурсаж тахилга өргөх болсон бөгөөд одоо ч энэ уламжлалаа хадгалж үлдсэн.

Ш. Хахы мауль тосгон

◦ Товч танилцуулга

Солонгосын Күнзийн шашны соёл хадгалагдан үлдсэн, хамгийн солонгос маягын бөгөөд өвөрмөц соёлтой. Хахы Рю овогтон хийгээд тэдгээрийн үр сад энд амьдардаг. Одоо 150 айл энэ тосгонд амьдарч байгаа нийт 127 сууцтай. Тэдгээрээс 12 сууц нь улсын хамгаалалтад байдаг.

Уг тосгоныхон багт бүжгээрээ алдартай. 2010 оны 7 сард Хахы мауль тосгоныг ЮНЕСКО дэлхийн өв санд бүртгэсэн.

MEMO

MEMO

The Association of North East Asia Regional Goverments

Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын
Холбооны Хэрэг эрхлэх газар
The Secretariat of the Association of North East Asia Regional Governments

A. 790-834 대한민국 경상북도 포항시 남구 지곡로 394(지곡동 601) 포항테크노파크 3층
790-834 3F, Pohang Techno Park, #394 Jigok-ro (#601 Gigok-dong), Nam-gu, Pohang City, Gyeongsangbuk-do
T. +82-54-223-2311~20 F. +82-54-223-2307,2309 H. www.neargov.org

CHINA +82-54-223-2320
JAPAN +82-54-223-2317
KOREA +82-54-223-2318
MONGOLIA +82-54-223-2384
RUSSIA +82-54-223-2319